



# НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

## Хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчил дутагдал, анхаарах асуудал

Илтгэгч нь: Барилгын техникийн хяналтын  
улсын ахлах байцаагч Л.БАТБАЯР

Улаанбаатар хот.

2018.10.09

# АГУУЛГА

- ❖ **УС ТАСЛАЛТ**
- ❖ **ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**
- ❖ **ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС**
- ❖ **ТООЛУУР**
- ❖ **ЗУРАГ ТӨСӨЛ, БИЧИГ БАРИМТ**
- ❖ **АЛБАН ШААРДЛАГА**

# Нэг. Ус таслалт

## ❖ Эрчим хүчний тухай хуулиас:

### ➤ 32 дугаар зүйл. Эрчим хүчний хангамж, хэрэглээг түдгэлзүүлэх

Эрчим хүчний хяналтын улсын байцаагч эрх үүргийнхээ хүрээнд үйл ажиллагааг бүхэлд нь буюу зарим тоног төхөөрөмжийн ашиглалтыг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болох заалтууд /32.1.-32.7. дахь 19-н заалт/ байдаг. Тухайлбал:

**32.1.2.** эрчим хүчний тоног төхөөрөмж, шугам сүлжээ нь ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй болсон;

**32.2.1.** эрчим хүч хэрэглэсний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй;

**32.2.2.** эрчим хүчний тоолуур, хэмжүүр, тэдгээрийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтыг дур мэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан;

**32.2.4.** хангагчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн хэрэглээний хүрээнээс өөр хэрэглэгчийг эрчим хүчээр хангасан;

**32.2.6.** хэрэглэгч өөрийн байранд нэвтрэн үзлэг хийх боломжийг хангагчийн эрх бүхий ажилтанд олгоогүй.



## **Нэг. Ус таслалт:**

❖ **Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиас:**

➤ **16 дугаар зүйл. Цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох нөхцөл**

**16.1. Хангагч дор дурдсан нөхцөлд хэрэглэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагаанд хязгаарлалт хийж болно:**

**16.1.1.** ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжид эрчим хүчний гэнэтийн тасалдал гарсан;

**16.1.2.** гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас усны хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай болсон;

**16.1.3.** ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид ноцтой гэмтэл гарсан.

## Нэг. Ус таслалт:

### ❖ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиас:

**16.2.** Хангагч дор дурдсан нөхцөлд хэрэглэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг **хязгаарлах буюу зогсоох хүртэл** арга хэмжээ авна:

**16.2.1.** хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд аюултай нөхцөл байдал үүссэн;

**16.2.2.** ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд төлөвлөгөөт урсгал болон их засвар хийх болсон;

**16.2.3.** цэвэр усны алдагдал, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн гэмтлийг тогтоосон хугацаанд засварлаагүй;

**16.2.4.** ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд хангагчийн зөвшөөрөлгүйгээр холбосон;

**16.2.5.** усны тоолуурын битүүмжлэл, байрлал, холболтыг дураараа өөрчилсөн;

**16.2.6.** энэ хуулийн 18.1-д заасны дагуу тогтоосон бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг хангаагүй бохир ус нийлүүлсэн.



## Нэг. Ус таслалт:

### ❖ Зөрчлийн тухай хуулиас:

- 6.2 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль зөрчих

**11.** Хангагч, эсхүл хэрэглэгч ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаархи хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй бол **учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.**

## Хоёр. Хамгаалалтын зурвас

### ❖ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиас:

#### ➤ 17 дугаар зүйл. Ус хангамж, ариутгах татуурга

**17.6.** Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш таван метрт хамгаалалтын зурвас тогтооно.

**17.7.** Хотын доторх цэвэр усны дамжуулах, түгээх, бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам ашиглалтын явцад засвар, үйлчилгээ хийх хамгаалалтын зурвас газартай байна.

**17.14.** Бохир ус татан зайлуулах шугамын тэнхлэгээс хоёр тийш зургаан метрээс багагүй зайд барилга байгууламж, шугам сүлжээг барихыг хориглоно.

- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм **БНБД 30.01.04-н** 14 дүгээр хүснэгтэд заасан инженерийн шугам сүлжээнээс барилга байгууламжийн суурь хүртэл хэмжээнүүд



# Хоёр. Хамгаалалтын зурвас

## ❖ Зөрчлийн тухай хуулиас:

- 6.2 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль зөрчих

**6. Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсэд зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж, шугам сүлжээ барьсан бол түүнийг буулгаж, үйл ажиллагааг зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг найман зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.**



## Гурав. Тоолуур

❖ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиас:

➤ 14 дүгээр зүйл. Хангагчийн эрх, үүрэг

14.2.4. өөрийн ашиглалт, өмчлөлд байгаа инженерийн барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид технологийн шаардлагын дагуу засвар, үйлчилгээ, шинэчлэлтийг тогтоосон хугацаанд нь хийх;

➤ 15 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрх, үүрэг

15.1.8. өөрийн эзэмшилд байгаа шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар, үйлчилгээг хариуцан гүйцэтгэх;

# Гурав. Тоолуур

## ❖ Зөрчлийн тухай хуулиас:

➤ 6.2 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль зөрчих

1. Усны тоолуурын битүүмжлэл, байрлал, холболтыг дураараа өөрчилсөн бол **учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.**



# Дөрөв: Тусгай зөвшөөрөл

## ❖ Зөрчлийн тухай хуулиас:

- 10.27 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан бол хүнийг **гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр**, хуулийн этгээдийг **гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр** торгоно.

## Тав. Зураг төсөл, бичиг баримт

### ❖ Барилгын тухай хуулиас:

- 46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг

**46.3.** Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох **архивт** шилжүүлнэ.



## Тав. Зураг төсөл, бичиг баримт

❖ Барилгын тухай хуулиас:

➤ 46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг

**46.1.12.** барилгын ашиглалтын хугацаанд барилга байгууламжийн баримт бичгийг баяжуулж, хадгалах;

## Тав. Зураг төсөл, бичиг баримт

❖ Зөрчлийн тухай хуулиас:

➤ 12.1 дүгээр зүйл. Барилгын тухай хууль зөрчих

**8. Барилга байгууламжийн ашиглагч, эзэмшигч хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.**



## **Зургаа. Албан шаардлага**

### **❖ Төрийн хяналт шалгалтын тухай хуулиас:**

- 13 дугаар зүйл.Хяналт шалгалтын талаархи байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг**

**13.2.** Байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан нь хяналт шалгалтын ажилд дэмжлэг туслалцаа үзүүлж, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, холбогдох арга хэмжээ авах талаар **тавьсан шаардлагыг биелүүлж, дүнг тогтоосон хугацаанд нь албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.**

# Зургаа. Албан шаардлага

## ❖ Зөрчлийн тухай хуулиас:


➤ 15.2 дугаар зүйл. Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах

1. Төрийн албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор:

1.1. тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг бусдад уриалсан;

1.2. хууль ёсны дагуу шаардсан холбогдох мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл санаатайгаар худал мэдээлэл өгсөн, эсхүл төөрөгдүүлсэн; ... бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.





Анхаарал тавьсанд  
баярлалаа.

АМЖИЛТ ХҮСЬЕ.